



**“МИК Холдинг” ХК-ийн хагас жилийн
үйл ажиллагааны тайлан**

2017 он

Агуулга


1. Компанийн товч танилцуулга	2
1.1 Байгууллагын бүтэц зохион байгуулалт	3
2. Удирдлагын талаарх мэдээлэл	4
2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт	4
2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ).....	4
2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ).....	4
2.3.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн:.....	5
2.3.2 ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг.....	6
2.4 Гүйцэтгэх удирдлага	7
2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл	8
3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл	8
3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр	8
3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл.....	8
4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл	9
5. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл	9

1. Компанийн товч танилцуулга

Монгол Улсын эдийн засагт орон сууцны санхүүжилтийн тогтвортой системийг олон улсын жишгийн дагуу бүрдүүлэх, орон сууцны санхүүжилтийн анхдагч болон хоёрдогч зах хот зээлийг тогтвортой, эрсдэлгүй, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж буй “МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг үүсгэн байгуулж, “МИК ОССК” ХХК-ийн толгой компани болгон бүтцийг нь өөрчилж, “МИК ОССК” ХХК-ийн хувьцааг “МИК Холдинг” ХХК-д шилжүүлэх шийдвэр гаргасан. 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “МИК Холдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг нээлттэй ХК болгон өөрчилснөөр 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар нийт 107 хувьцаа эзэмшигчтэй болоод байна.

“МИК Холдинг” ХК нь хувьцаагаа нийтэд нээлттэй арилжаалдаг хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Хувьцаат компанийн I-р ангилалд багтахын зэрэгцээ өөрийн охин компани болох “Монголын Ипотекийн корпораци ОССК” ХХК-ийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулдаг.

1.1 Байгууллагын бүтэц зохион байгуулалт



2. Удирдлагын талаарх мэдээлэл

2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

“МИК Холдинг” ХК нь 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах ажлын байранд 8 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“МИК Холдинг” ХК-ийн бүтэц дэх албан тушаал, ажилтны тоо:

Албан тушаал	Ажилтны тоо
Гүйцэтгэх захирал	1
ТУЗ-ийн Ажлын албаны дарга	1
Ахлах аудитор	1
Дотоод аудитор	2
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1
ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2
НИЙТ	8

Эдгээр удирдлага, албан тушаалтууд “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК болон түүний охин компаниуд болох МИК Актив Нэгээс-Арван дөрөв хүртэлх ТЗК-иудын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор “МИК ОССК” ХХК-тай ажлын хэлхээ холбоогоо хадгалан хамтран ажиллаж байна.

2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

“МИК Холдинг” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл болон Компанийн Дүрмийн дагуу ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд жилд нэг удаа зарлан хуралдуулдаг. ХЭХ нь Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан болон компанийн тухай хуульд заасан бусад асуудлыг тухай бүр хэлэлцэж, шийдвэр гаргадаг.

2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас бусад тохиолдолд Компанийн удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн засаглалын олон улсын жишигт нийцүүлэн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, Компанийн дүрэмд заасны дагуу 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хувьцаа эзэмшигч банкуудын төлөөлөл (Монголбанк, Голомт банк, Капитал банк, Худалдаа хөгжлийн банк, Хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк) 6 ердийн гишүүн болон 3 хараат бус гишүүн сонгогдон ажиллаж байна.



2.3.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн

М.Мөнхбаатар нь Улаанбаатар Хотын Банкны Зөвлөх бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон. 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар улиран ТУЗ-ийн даргаар сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны даргаар ажилладаг.

Б.Ганбат нь Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны дарга болон Үйл ажиллагаа эрх зүйн хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Л.Гантөмөр нь Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр улиран сонгогдсон.. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Б.Чойжилжалбуу нь Монгол Улсын Хөгжлийн банкны Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газрын захирлаар ажилладаг. 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр улиран сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагаа эрх зүйн хорооны даргаар ажилладаг.

Б.Энхтуяа нь Голомт банкны Бизнес хөгжлийн газрын захирал бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү аудитын хороо, Үйл ажиллагаа эрх зүйн хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Д.Бадамчулуун нь Капитал банкинд Эрсдэлийн удирдлагын газрын захирал албан тушаалтай. 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны болон Үйл ажиллагаа эрх зүйн хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Э.Шижир нь 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр улиран сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хорооны дарга болон Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Ч.Отгочулуу нь “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн зөвлөх бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо болон Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Ч.Хашчулуун нь Монгол улсын их сургуулийн профессор бөгөөд 2017 оны дугааргүйн 19-ний өдрийн “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 17/17 тоот тогтоолообр ТУЗ-ийн тур орлох хараат гишүүнээр томилогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хороо, Уйл ажиллагаа эрх зүйн хороо болон Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

2.3.2 ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

Компанийн засаглалын зөв бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгч ажилладгийн хувьд Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурал, түүний дэргэдэх хороодын хурлыг тогтмол зохион байгуулж, эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэн ажилладаг. МИК Холдинг ХК-ийн ТУЗ-ийн Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Уйл ажиллагаа, эрх зүйн хороо, Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хороо гэсэн 4 хороо үйл ажиллагаа явуулж байна.

Санхүү аудитын хороо нь ТУЗ-д удирдах чиглүүлэх болон хянан шалгах үүргээ үр ашигтай бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслах, ялангуяа компанийн санхүүгийн тайлан, дотоод хяналтын бодлого журмын үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулах, хөндлөнгийн болон дотоод аудитортой харилцан ажиллах нягтлан бодох бүртгэл, санхүүгийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт өгөх, мэдээлэл зөвлөмжөөр хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын хороо нь МИК Холдинг ХК-ийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд зах зээлийн болон зээлийн эрсдэлийг урьдчилан тооцож, ТУЗ-өөс баталж өгсөн компанийн төлөвлөгөөний хэрэгжилтэд зэрэг учирч болох олон талт эрсдэлээс хамгаалах дүгнэлт гаргах, эрсдэлээс хамгаалах бодлого, журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавир, зөвлөмж мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Үйл ажиллагаа эрх зүйн хороо нь Компанийн үйл ажиллагааны стратегийн төлөвлөлт түүний хэрэгжилт, үйл ажиллагааны дүрэм журам, гэрээ хэлцэл, эрх зүйн орчин бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх шаардлагатай мэдээлэл зөвлөмжөөр хангах, дүгнэлт гаргах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох бүрэн эрхийн хугацааг цуцлах болон сунгах, компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлого тодорхойлох, компанийн хүний нөөц бүрдүүлэх, ажиллагсдыг тогтвортой үр бүтээлтэй ажиллуулах чиглэлээр асуудал хэлэлцэх, дүгнэлт гаргах чиг үүрэг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн Хороодын бүрэлдэхүүн

Өнгөрсөн онд ТУЗ-д төлөөлөлгүй хувьцаа эзэмшигч банкуудын эрх бүхий албан тушаалтнуудыг ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнд сонгон ажиллуулдаг байсан бол МИК Холдинг ХК-ийн 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнийг зөвхөн ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй байх шийдвэрийг гаргасан. Үүнд:

№	Хороо	Гишүүдийн тоо	Гишүүд	Албан тушаал
1	Санхүү, аудитын хороо	5	Э.Шижир Б.Энхтуяа Ч.Отгочулуу Л.Гантөмөр Ч.Хашчулуун	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
2	Эрсдэлийн удирдлагын хороо	5	Б.Ганбат Л.Гантөмөр Д.Бадамчулзуун Б.Энхтуяа Ч.Отгочулуу	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
3	Үйл ажиллагаа, эрх зүйн хороо	5	Б.Чойжилжалбуу Д.Бадамчулзуун Б.Энхтуяа Б.Ганбат Ч.Хашчулуун	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
4	Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо	4	М.Мөнхбаатар Э.Шижир Ч.Отгочулуу Ч.Хашчулуун	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн

2.4 Гүйцэтгэх удирдлага

2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар Дамдин овогтой Гантөгсийг Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, Бадамхатан овогтой Гантулгыг Гүйцэтгэх захирлаар томилсон.

Гүйцэтгэх захирлын талаархи мэдээлэл:

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлagnана. “МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрхийн хүрээнд дараахь эрхийг хэрэгжүүлнэ:

- Компанийн Гүйцэтгэх захирлын хувиар Компанийн болон бизнес хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар ТУЗ-д саналаа танилцуулж, чиглэл авч Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх;

- Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хууль тогтоомжид заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй зэрэг хэлцэл хийх тохиолдолд тухай бүрт нь ТУЗ-аас олгосон итгэмжлэлийн дагуу оролцох;
- Компанийн хөрөнгийн удирдлага, өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанаас бусад компанийн хөрөнгө оруулалт, бусад эд хөрөнгө худалдах, худалдан авах зэрэг хэлцлийг ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хийх.

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга нь эдийн засагч мэргэжилтэй, 1997-2001 онд МУИС-ийн харьяа “Эдийн засгийн сургууль”-ийг санхүүч, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, 2007-2008 онд Австрали улсын “Австралийн үндэсний их сургууль”-ийг санхүүгийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан. 2001 оноос Сангийн яам, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банкинд мэргэжилтэн, эдийн засагч, УБ Капитал ХХК, Улаанбаатар хотын банк, Сангийн яаманд газрын дарга, Дэд захирлаар тус тус ажиллаж байсан. Тэрээр 2017 оны 05-р сард “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус томилогдсон ба бусад ямар нэгэн өр зээлгүй, ял шийтгэлгүй, хууль хяналтын байгууллагад үүсгэн шалгагдаж байгаа зөрчилгүй болно.

2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	Б.Гантулга	Гүйцэтгэх захирал	Монгол
2	Ж.Онон	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албаны дарга	Монгол
3	Ц.Алтантуяа	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Монгол
4.	А.Гэрэлцэцэг	Ахлах аудитор	Монгол

3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2017 оны 17/07 тоот шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 дугээр сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 87.57 хувийн ирцтэйгээр хуралдаж, 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн зардлын төсөв зэргийг хэлэлцэж баталсан. Мөн тус хуралдаанаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг сонгосон.

3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “МИК Холдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг нээлттэй ХК болгон өөрчилснөөр 2015 онд 12 хувьцаа эзэмшигчидтэй байсан “МИК Холдинг” ХХК нь “МИК Холдинг” ХК

болсноор 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар нийт 107 хувьцаа эзэмшигчидтэй болоод байна. Үүнээс Компанийн нийт хувьцааны 19,31 хувийг, Төрийн өмчит байгууллагууд 80,64 хувийг, Аж ахуй нэгжүүд, 0,05 хувийг иргэд эзэмшиж байна. 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчдийн нэrsийг дараах байдлаар харуулав. Үүнд:

№	Байгууллагын нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Улаанбаатар Хотын Банк	25.46 %
2	Худалдаа Хөгжлийн Банк	20.66 %
3	Монгол Улсын Хөгжлийн Банк	14.88 %
4	Капитал Банк	8.12 %
5	"Ти Ди Би Капитал УЦК" ХХК	7,49%
6	Голомт Банк	5.57 %
7	"МИК ОССК" ХХК	9.98%

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

“МИК Холдинг” ХК-ийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №17/05 тоот тогтоолоор 2016 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаандaa 471.6 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэж, Ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэrsийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 04 дүгээр сарын 05-ний өдрөөр тасалбар болгон тогтоосон. Ногдол ашгийг Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэдээ 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хуваарилан шилжүүлсэн.

5. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

“МИК Холдинг” ХК-ийн хөрөнгө оруулалттай “МИК ОССК” ХХК нь 2017 оны эхний хагас жилд “МИК Актив Арав ТЗК” ХХК, “МИК Актив Арван нэг ТЗК” ХХК, “МИК Актив Арван хоёр ТЗК” ХХК-иудыг шинээр үүсгэн байгуулж, нийт 426.31 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргасан бөгөөд мөн хугацаанд МИК Актив нэг-Актив арван нэг ТЗК ХХК-иас зөвхөн бонд эзэмшигчдэд 2017 оны эхний хагас жилийн байдлаар давуу эрхтэй бондын үндсэн төлбөрт нийт 92.13 тэрбум төгрөг, давуу болон энгийн бондын купоны төлбөрт 56.77 тэрбум төгрөгийг тус тус төлөөд байна.

**МИК ХОЛДИНГ ХК ГРУППИЙН 2017 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ
БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**



ХӨРӨНГӨ

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	183,408,139.47
Дансны авлага	674,534.82
Хөрөнгө оруулалт	1,000.00
Бусад санхүүгийн хөрөнгө	2,486,024,217.08
Бусад санхүүгийн бус хөрөнгө	551,196.85
Үндсэн хөрөнгө	14,512,416.87
Биет бус хөрөнгө	50,152.77
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,685,221,657.86

ӨР ТӨЛБӨР

Дансны өглөг	893,830.46
Татварын өр	1,069,943.51
Хүүний өглөг	17,843,938.63
Урьдчилж орсон орлого	3,652.24
Бусад богино хугацаат өр төлбөр	3,375,816.73
Богино хугацаат зээл	600,000.00
Урт хугацаат зээл	8,440,772.06
Бусад урт хугацаат өр төлбөр	2,492,659,138.41
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,524,887,092.04

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувьцаат өмч	20,709,320.00
Халаасны хувьцаа	(24,057,435.6)
Нэмж төлөгдсөн капитал	52,225,114.83
Хуримтлагдсан ашиг	75,401,191.06
Тайлант оны ашиг	36,056,375.53
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	160,334,565.82

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН:	2,685,221,657.86
---	-------------------------

Хүүгийн орлого	102,587,001,59
Хүүгийн зардал	59,492,702,51

ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО	43,094,299.08
-----------------------------	----------------------

Хүүгийн бус орлого/зардал	(7,037,923.55)
Цэвэр ашиг	36,056,375.53

Нийт активын хэмжээ 2017 оны 06-р сарын 30-ны байдлаар 2,685.2 тэрбум төгрөгийн тайлант хугацаанд 103.6 тэрбум төгрөгийн орлого, 67.5 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар татварын дараах цэвэр ашгийг 36.05 тэрбум төгрөгт хүргэж ажилласан байна.

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

Ашиг ажиллагаа

Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	1,3%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	22,48%

Өсөлтийн харьцаанууд

Нийт активын өсөлт	15,6%
Зээлийн багцын өсөлт	15,5%
Баталгаажсан бондын өсөлт	15,5%

Хөрөнгийн харьцааны үзүүлэлтүүд

Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	5,8%
-----------------------------	------

Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэмжээ нийт хөрөнгийн 92.5 хувийг, өөрийн хөрөнгийн хэмжээ 5.8 хувийг бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 15.6 хувиар өсөхөд ИЗББ-ын хэлцлийн хэмжээ 15.5 хувиар өссөн нь нөлөөлсөн. 2017 оны 06-р сарын 30-ны байдлаар активын өгөөж 1.3%, өөрийн хөрөнгийн өгөөж 22.48% тус тус үзүүлэлттэй байна.